ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДОА-2021/142/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2021 он


Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар |
| ХБИ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |

## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан....10
3. Аудитын тайлан....11
3.1. Ерөнхий зүйл....11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй....11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт....11
3.4. Материаллаг байдал....12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд....12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт....13
3.7. Шилэн дансны мэдээлэл....14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....14
3.9. Аудитын илрүүлэлт....14
Залруулсан алдаа....14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил....14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд....14
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт....15

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.17 № 60

танай ____________-ны № ______________-т

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА Б.САРАНЧИМЭГ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,437,030.00** | **6,809,422.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| 31110 | Төгрөг | - | - |
| **3121** | **Төгрөг** | - | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | - |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | - |
| **33** | **АВЛАГА** | - | 1,886,775.00 |
| **335** | **Бусад авлага** | - | 1,886,775.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 1,886,775.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | - |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 40,043,901.75 | 41,458,191.90 |
| 391 | Газар | - | - |
| **392** | **Биет хөрөнгө** | 39,902,734.92 | 41,458,191.90 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 58,827,100.00 | 34,827,100.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (34,157,904.12) | (15,962,420.76) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 23,035,360.00 | 32,242,790.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (12,203,094.12) | (13,157,474.03) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 8,925,500.00 | 8,925,500.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (4,524,226.84) | (5,417,303.31) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 141,166.83 | - |
| 39301 | Програм хангамж | 770,000.00 | 770,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (628,833.17) | (770,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **43,480,931.75** | **48,267,613.90** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **1,886,775.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 1,886,775.00 |
| **413** | **Өглөг** | - | 1,886,775.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 1,886,775.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 1,886,775.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **43,480,931.75** | **46,380,838.90** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 43,480,931.75 | 46,380,838.90 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 43,480,931.75 | 46,380,838.90 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 43,480,931.75 | 43,480,931.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 2,899,907.15 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **43,480,931.75** | **48,267,613.90** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **211,656,332.00** | **221,727,473.00** |
| 11 | **ТАТВАРЫН ОРЛОГО** | - | - |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | - | **10,062,500.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | - | 10,062,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 10,062,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 10,062,500.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **211,656,332.00** | **211,664,973.00** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 14,363,432.00 | 8,378,673.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 14,363,432.00 | 8,378,673.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | - |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 197,292,900.00 | 203,286,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 197,292,900.00 | 203,286,300.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **212,191,629.24** | **218,827,565.85** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **212,191,629.24** | **218,827,565.85** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 196,237,484.27 | 209,442,967.48 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 136,259,117.00 | 150,771,298.00 |
| 210101 | Үндсэн цалин | 130,004,117.00 | 148,940,087.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,255,000.00 | 1,831,211.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,652,530.23 | 18,823,525.86 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,435,667.23 | 12,994,665.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,321,569.00 | 1,372,113.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,101,810.00 | 1,188,465.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 455,496.00 | 297,116.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,337,988.00 | 2,971,166.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 3,864,200.00 | 4,374,875.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 629,563.00 | 871,299.00 |
| 210302 | Түлш, халаалт | 969,722.00 | 1,167,068.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 629,915.00 | 336,508.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,635,000.00 | 2,000,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 11,893,620.80 | 9,967,585.77 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,010,013.00 | 2,426,737.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,235,700.00 | 5,250,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,838,858.80 | 1,404,042.77 |
| 210404 | Ном, хэвлэл | 310,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 70,190.00 | 28,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 428,859.00 | 858,206.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,499,991.00 | 2,400,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,499,991.00 | 2,400,000.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 13,552,000.00 | 10,238,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,552,000.00 | 10,238,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 675,850.00 | 719,075.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 240,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 98,010.00 | 81,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 49,340.00 | 75,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 266,500.00 | 299,700.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,840,175.24 | 12,148,607.85 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 547,500.00 | 749,408.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 10,292,675.24 | 11,399,199.85 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 15,954,144.97 | 9,384,598.37 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,000,000.00 | 811,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 811,400.00 |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 14,954,144.97 | 8,573,198.37 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,954,144.97 | 8,573,198.37 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(535,297.24)** | **2,899,907.15** |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(535,297.24)** | **2,899,907.15** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **211,656,332.00** | **211,664,973.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | - | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **211,656,332.00** | **211,664,973.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 14,363,432.00 | 8,378,673.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 14,363,432.00 | 8,378,673.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 197,292,900.00 | 203,286,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 197,292,900.00 | 203,286,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **211,656,332.00** | **211,664,973.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **211,656,332.00** | **211,664,973.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **195,702,187.03** | **202,280,374.63** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 136,259,117.00 | 150,771,298.00 |
| 210101 | Үндсэн цалин | 130,004,117.00 | 148,940,087.00 |
| 210102 | Нэмэгдэл | - | - |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,255,000.00 | 1,831,211.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,652,530.23 | 18,823,525.86 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,435,667.23 | 12,881,195.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,321,569.00 | 1,485,583.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,057,256.00 | 1,188,465.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 258,005.00 | 297,116.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,580,033.00 | 2,971,166.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 3,864,200.00 | 4,374,875.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 749,132.00 | 871,299.00 |
| 210302 | Түлш, халаалт | 969,722.00 | 1,167,068.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 510,346.00 | 336,508.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,635,000.00 | 2,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,677,748.80 | 10,485,600.77 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,175,241.00 | 2,212,593.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,235,700.00 | 5,250,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,892,758.80 | 1,404,042.77 |
| 210404 | Ном, хэвлэл | 585,000.00 | 567,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 70,190.00 | 28,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 718,859.00 | 1,023,365.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,489,991.00 | 5,818,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,990,000.00 | 3,418,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,499,991.00 | 2,400,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,552,000.00 | 10,238,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,552,000.00 | 10,238,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,** | 1,566,600.00 | 764,075.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 240,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 98,010.00 | 81,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 49,340.00 | 75,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 856,500.00 | 344,700.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 300,750.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,640,000.00 | 1,005,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,640,000.00 | 1,005,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **15,954,144.97** | **9,384,598.37** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,000,000.00 | 811,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 811,400.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 14,954,144.97 | 8,573,198.37 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,954,144.97 | 8,573,198.37 |
| 213404 | Хөрөнгийн | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 8,998,407.69 | 8,998,407.69 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **8,998,407.69** | **8,998,407.69** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | 00.00 | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 1,920,329.93 | 1,920,329.93 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **43,480,931.75** | **43,480,931.75** |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **43,480,931.75** | **43,480,931.75** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **43,480,931.75** | **43,480,931.75** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | 00.00 | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 2,899,907.15 | 2,899,907.15 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **46,380,838.90** | **46,380,838.90** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 218,243,000.00 | 203,286,300.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 218,243,000.00 | 203,286,300.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 217,243,000.00 | 202,280,374.63 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 158,519,400.00 | 150,771,298.00 |
| 210101 | Үндсэн цалин | 156,003,800.00 | 148,940,087.00 |
| 210102 | Нэмэгдэл | - | - |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,515,600.00 | 1,831,211.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,814,900.00 | 18,823,525.86 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,474,250.00 | 12,881,195.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,585,200.00 | 1,485,583.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,268,050.00 | 1,188,465.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 317,000.00 | 297,116.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,170,400.00 | 2,971,166.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 5,403,100.00 | 4,374,875.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,016,400.00 | 871,299.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1,570,000.00 | 1,167,068.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 816,700.00 | 336,508.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,350,600.00 | 10,485,600.77 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,479,000.00 | 2,212,593.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,300,000.00 | 5,250,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,420,000.00 | 1,404,042.77 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 567,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ар | 171,600.00 | 28,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 480,000.00 | 1,023,365.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,918,000.00 | 5,818,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,418,000.00 | 3,418,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,500,000.00 | 2,400,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,560,000.00 | 10,238,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,560,000.00 | 10,238,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,** | 1,637,000.00 | 764,075.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 240,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 100,000.00 | 81,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 100,000.00 | 75,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 860,000.00 | 344,700.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 375,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,040,000.00 | 1,005,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,040,000.00 | 1,005,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,000,000.00 | 1,005,925.37 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | 194,525.37 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,000,000.00 | 811,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 811,400.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 218,243,000.00 | 203,286,300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 218,243,000.00 | 203,286,300.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 218,243,000.00 | 203,286,300.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **8,378,673.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **8,378,673.00** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **8,378,673.00** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | - |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 8,378,673.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 8,378,673.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 8,378,673.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,378,673.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | - |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Б.Саранчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Санхүүгийн хяналт, аудитын алба 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Санхүүгийн хяналт, аудитын албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих,
- Төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах,
- Эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Санхүүгийн хяналт, аудитын алба нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сангийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 218,827.6 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 4,376.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,786.7 мянган төгрөгөөр буюу 11 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 1,886.8 | 1,886.8 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 3,437.0 | 4,922.6 | 1,485.6 |
| Үндсэн хөрөнгө | 40,043.9 | 41,458.2 | 1,414.3 |
| **Нийт хөрөнгө** | **43,480.9** | **48,267.8** | **4,786.7** |
| Өр төлбөр | - | 1,886.8 | 1,886.8 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 43,480.9 | 46,380.8 | 2,899.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **43,480.9** | **48,267.6** | **4,786.7** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 1,886.8 мянган төгрөг болж өссөн ХБИ ажилтнаас ХХОАТ суутган тооцсоноос шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэл 1,886.8 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 4,922.6 мянган төгрөг болж 1,485.6 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай аж ахуйн материалыг худалдан авсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 41,458.2 мянган төгрөг болж 1,414.3 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар 10,601.0 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 3,149.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжөөр тус тус нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгө акталсан 28,543.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,886.8 мянган төгрөг болж өссөн нь ХБИ ажилтнаас ХХОАТ суутган тооцсоноос шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 46,380.8 мянган төгрөг болж 2,899.9 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 10,071.1 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 6,635.9 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардлууд байна. Энэ нь ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолоор цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

## 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 218,243.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 218,243.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг хэвээр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 218,243.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 218,243.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 218,243.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 203,286.3 мянган төгрөгийг зарцуулж 14,956.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 203,286.3 мянган төгрөг буюу 93.1 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 7,748.1 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 991,4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал 1,028.2 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардал 1,050.0 мянган төгрөгөөр, томилолтын зардал 3,322.0 мянган төгрөгөөр, бусад төлбөр хураамжийн зардал 817.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь ковид-19 цар тахал гарсантай холбоотой төрийн албаны шалгалт хойшлогдсонтой холбоотой орон тоо дутуу ажилласан, төлөвлөгөөт хяналт шалгалт бүрэн хийгдээгүйгээс шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 8,4 сая төгрөгийн төлбөрийн акт орсныг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,300.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,773.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,886.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,886.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос 1,886.8 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган авч шилжүүлсэн байгаа бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажуулан авлага, өглөгөөр бүртгээгүй байсныг залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1,886.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос 1,886,775 төгрөгийн татвар суутган авсан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д "дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.2-т "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д "хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Албан шаардлага хүргүүлэв.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутгаан тооцсон байна. Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Аудитын код: |
|---|---|---|
| 2020 | ***Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | ДОА-2021/142/СТА-ТШЗ |

| Шалгагдсан байгууллагын нэр: | ***Санхүүгийн хяналт, аудитын алба*** | Мянган төгрөгөөр |
|---|---|---|

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Хууль зөрчин цалингаас суутган авсан татварыг авлага, өр төлбөрөөр бүртгээгүй | 1,886.8 | Авлага, өр төлбөрөөр бүртгүүлсэн | Нягтлан бодогч | Д.Сэвжил |
| 2 | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган авсан | 1,886.8 | Албан шаардлага | Нягтлан бодогч | Д.Сэвжил |
| **ДҮН** | | **3,773.6** | | | |